

ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАГНАЛ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа	2022 он
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Тандэм Инвэст ББСБ ХК, 9010001130, MN00VIK04383, 88924523
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк санхүү
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Шинэ Их тэрбум Аудит ХХК, 2017-05-10
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1.508.116.708
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Ж.Ганхүлэг, Гүйцэтгэх захирал

1	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Хавсралтаар
	Орлогын тайлан	Хавсралтаар
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Хавсралтаар
	Мөнгөн гүйлгээний тайлан	Хавсралтаар

1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	Хавсралтаар
-----	--	-------------

1.2	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/	Хавсралтаар
-----	---	-------------

2	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өсгөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
---	--	--

2.1	Үйл ажиллагааны үр дүн/ санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Хөрөнгийн өгөөж-15.9% Хөрөнгийн өгөөж-19.8% Хөрөнгө, эрсдлээр жигнэсэн нийт активын харьцаа-64.2% Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа-79.1%	Өөрийн Өөрийн
-----	---	--	------------------

2.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа-16.5% Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа-2.7% Үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа-24.3%	Итгэлцлийн
-----	---	--	------------

2.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Компанийн зүгээс тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын зээл болон автомашины зээлийн хэмжээнд өөрчлөлт оруулсан. Мөн шинээр 1 төрлийн зээлийн бүтээгдэхүүний нөхцөл баталсан.	Мөн
-----	--	---	-----

2.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл	Санхүү байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил үйлчилгээ байхгүй. Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартыг нягтлан бодох бүртгэлд дагаж мөрддөг. Компанийн 2021 оны 2 дугаар сарын 02 өдрийн ТУЗ-ын 03 тоот тогтоолоор баталсан Нягтлан бодох бүртгэлийн зааварчилгаа ашигладаг.	
-----	--	--	--

2.5	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа баталгааны талаарх мэдээлэл	Байхгүй.	
-----	--	----------	--

3	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй, этгээдийн талаарх мэдээлэл/тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана.		
---	---	--	--

Тайлант хугацаанд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн болно. Хөрөнгө оруулалтын зуучлалын гэрээ, СИКАП ҮЦК ХХК

4	Цалин урамшууллын мэдээлэл		
---	----------------------------	--	--

	Санхүүгийн жилд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулалд 75.2 сая төгрөгийн зардал гарсан болно.	ТУЗ-н гишүүдийн эзэмшиж буй хувьцаа: 1,765 ш	Ч.Тэмүдэр- Б.Золжаргал-1,750 Ц.Билэг-Өрнөх-1,750 ш
--	--	---	--

5	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл		
---	--	--	--

	Тайлант хугацаанд компанийн ТУЗ гишүүд сонгогдож ТУЗ-ийн дэргэдэх хороодыг шинээр томилсон. Гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт орсон болно. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 3 дүгээр сарын 23-ны өдрийн 03 тоот тогтоолоор 3 жилийн хугацаатай томилсон. Ч.Чинзориг, Ц.Билэг-Өрнөх, Ч.Тэмүдэр, Б.Золжаргал, Л.Очирмаа, Ч.Бадмаарэг Ч.Лодойравсал, Б.Энх-Амгалан, А.Даваазориг Ж.Ганхүлэг нь 2022 оны 08 сарын 08-ны 19 тоот тогтоолоор томилогдсон.		Ердийн гишүүд- Хараат бус гишүүд- Гүйцэтгэх удирдлага нь
--	--	--	--

6	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл		
---	--------------------------------	--	--

Компанийн зүгээс цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан зээлийн эргэн төлөлтөнд судалгаа хийж, харилцагчийн орлоготой уялдуулан зээлийн графикт өөрчлөлт оруулснаар зээлийн эрсдлийн сангийн зардлыг бууруулсан.

7 Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо
Ч.Чинзориг-33.3% буюу 502,873,521ш
32.5% буюу 489,561,300 ш
буюу 512,372,636 ш

Ш. Михоко-
Ш.Такаёши-33.9%


8 Үнэт цаас гаргач нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлсэнээ хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл

Компани тайлант хугацаанд хаалттай хүрээнд 377,029,177 ширхэг энгийн хувьцаа нэмж гарган 7.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татаж, эргэлтийн хөрөнгөнд зарцуулсан.


9 Ногдол ашгийн мэдээлэл
Компани тайлант хугацаанд 886 хувьцаа эзэмшигчдэд 961.4 сая төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн. Үүнээс 3 том хувьцаа эзэмшигч нь 810.5 сая төгрөгийг итгэлцэлд байршуулсан.

10 Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
Нийгмийн хариуцлагын хүрээнд оюутнуудад сургалтын төлбөрийн тэтгэлэг олгосон.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

 Овог,нэр: Ж.Ганхүлэг тушаал: Тэйдэм Инвест ББСБ ХК-ийн гүйцэтгэх захирал үсэг: (Тамга/гэмдэг)	Албан Гарын	Овог,нэр:..... тушаал".....". К-ийн гүйцэтгэх захирал үсэг:..... (Тамга/гэмдэг)	Албан Гарын
---	----------------	--	----------------

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

 Овог,нэр: Б.Бадамцэцэг тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Албан Гарын үсэг:
---	----------------------

Энгийн хувьцаа эзэмшигчдийн нэр	Хувьцааны тоо	Хувьцааны хувь
Ш. Михоко	175,000,000	33.9%
Ш. Такаёши	175,000,000	33.9%
Ч. Чинзориг	502,873,521	33.3%
Бусад эзэмшигчид	489,561,300	32.5%
Нийт	1,242,434,821	100%



**ШИНЭ ИХ ТЭРБУМ
АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
1-р хороо, 12-р хороолол, North center, 204 тоот
Утас: 9919-9075, 8804-3708, И-мэйл: Ikhterbum@gmail.com

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ТАНАА

2023.01.16 № 23/02
танай _____-ны № _____-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “Тандэм инвест ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нэмэлт тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр компанийн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”)-ын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайланд аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан.

Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НБЭЗОУСЗ”)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайланд ББСБ-ын удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах болон алдаа эсвэл залилангаас үүдэлтэй материаллаг алдаатай илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)
"ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ" ХК-ийн хувьцаа эзэмшигчид танаа

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлдэг гэсэн баталгаа гаргадаггүй.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу зөвхөн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Д.Данцдулам -Туйцэтгэх захирал, МНБ

"ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ" ХК

АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУДЫН ХУРААНГУЙ
2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

(Төгрөгөөр)

БАЛАНС

	12/31/2022	12/31/2021
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	621,309,138	449,569,419
Зээл (цэвэр)	16,649,740,632	6,326,741,104
Бусад авлага	259,179,859	79,001,295
Бусад хөрөнгө	3,399,730	90,908,432
Үндсэн хөрөнгө (цэвэр)	486,454,309	43,659,304
Биет бус хөрөнгө (цэвэр)	1,930,521	2,661,771
Нийт хөрөнгийн дүн	18,022,014,189	6,992,541,325
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	3,464,131,004	1,008,801,600
Бусад өр төлбөр	301,447,000	111,835,786
Хувьцаат капитал	3,465,098,908	2,597,931,801
Нэмж төлөгдсөн капитал	8,779,112,743	2,294,210,877
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	2,012,224,534	979,761,261
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	18,022,014,189	6,992,541,325

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Хүүгийн орлого	3,051,928,920	1,138,252,209
Хүүгийн бус орлого	181,935,423	39,070,261
Хүүгийн бус зардал	(899,768,500)	(378,348,339)
Зээлийн эрсдэлийн зардал	(51,154,298)	-
Үндсэн үйл ажиллагааны ашиг	2,282,941,545	798,974,131
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	267,300	205,677,853
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	(62,268,328)	(22,464,888)
Татвар төлөхийн өмнөх ашиг	2,220,940,517	982,187,096
Орлогын албан татвар	(227,324,564)	(10,053,419)
Цэвэр ашиг (алдагдал)	1,993,615,953	972,133,677

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Хувьцаат капитал	3,468,668,428	2,601,501,321
Халаасны хувьцаа	(3,569,520)	(3,569,520)
Нэмж төлөгдсөн капитал	8,779,112,743	2,294,210,877
Хуримтлагдсан ашиг	2,012,224,534	979,761,261
Нийт эздийн өмчийн дүн	14,256,436,185	5,871,903,939

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	14,840,857,279	6,061,957,665
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	(21,606,234,998)	(8,568,031,581)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(6,765,377,719)	(2,506,073,916)
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	7,456,432,929	2,580,419,559
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	(519,315,491)	(69,091,026)
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	6,937,117,438	2,511,328,533
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	171,739,719	5,254,617
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	449,569,419	444,314,802
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	621,309,138	449,569,419

Хавсралт тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.



**ШИНЭ ИХ ТЭРБУМ
АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
1-р хороо, 12-р хороолол, North center, 204 тоот
Утас: 9919-9075, 8804-3708, И-мэйл: lkhterbum@gmail.com

2023.01.03 № 23/01
танай _____-ны № _____-т

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК-Д

Гэрээт ажлын захидал

Манай хоёр байгууллагын хооронд байгуулсан “Аудитын үйлчилгээ үзүүлэх” гэрээнд танай компанийн 2022 оны 12 дугаар сарын 31ний өдрөөр гаргасан баланс, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын тайлан, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийхээр харилцан тохиролцсон билээ. Энэхүү захидлаараа гэрээт ажлын талаар өөрсдийн ойлголтоо илэрхийлж байна.

Бидний зүгээс үзүүлэх аудитын үйлчилгээний зорилт нь танай байгууллагын санхүүгийн тайлагналд санал дүгнэлт өгөх бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу гүйцэтгэх болно. Энэхүү стандартын дагуу “Санхүүгийн тайлангууд” нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэдэг үндэслэлтэй нотолгоо олж авах зорилгоор аудитын ажлыг төлөвлөж, гүйцэтгэх, ёс зүйн шаардлагуудыг мөрдөж ажиллахыг шаарддаг. Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудит нь мөн байгууллагын удирдлагын сонгон хэрэглэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой эсэх, нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудын бодитой эсэхийг үнэлэх ажлууд багтана. Иймд танай байгууллагын холбогдох албан тушаалтан, ажилтнууд нь гэрээт ажлын явцад идэвхи, санаачилгатай оролцоно гэдэгт эргэлзэхгүй байна.

Аудитын үйлчилгээний явцад хэрэглэж буй арга, уламжлалт шинж чанар, нягтлан бодох бүртгэлийн ба дотоод хяналтын системийн хязгаарлагдмал байдлын улмаас зарим материаллаг зөрчлийг илрүүлэхгүй, зарим алдаатай зүйлс гарах магадлалыг үгүйсгэхгүй боловч аудитын эрсдэлийг хамгийн бага байлгахуйцаар үзүүлэх үйлчилгээг зохион байгуулах болно.

Танай байгууллагын тайлант жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулсан хараат бус аудитын тайланг нэмэлт тодруулгын хамт хүргүүлэхдээ нягтлан бодох бүртгэл, хууль эрх зүйн орчны нийцтэй байдлыг тусган, дотоод хяналтын системийн эрсдэлтэй сул талуудыг үнэлж, цаашид засч сайжруулах талаар дэлгэрэнгүй зөвлөмжийг бичиж хуулийн болон гэрээний хугацаанд удирдлагад хүргүүлэх болно.

Аудитын үйлчилгээ үзүүлэх явцад бидний бэлтгэсэн ажлын баримтууд нь манай байгууллагын өмч бөгөөд нууцлалын зэрэглэлтэй хадгалагдах болно. Холбогдох хууль журмын хүрээнд эрх бүхий субъектэд дээрх бичиг баримтуудыг гаргаж өгөх талаар хүсэлт тавьсан тохиолдолд манай компанийн холбогдох албан тушаалтан, ажилтны хяналтын дор гаргаж өгч болно.

Санхүүгийн тайланг зохих нэмэлт тодруулгын хамт бэлтгэх нь компанийн удирдлагын хариуцлага гэдгийг сануулахыг хүсч байна. Үүнд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож хэрэглэх, дотоод хяналтын системийг ханган ажиллах, байгууллагын нөөц, хөрөнгийн орлого, найдвартай хадгалалт, хамгаалалт, үр ашигтай захиран зарцуулах, дансны бичилт зэрэг зүйлс багтана.

Бид танай хамт олонтой хамтран ажиллах чин эрмэлзэлтэй байгааг илэрхийлэхийн хамт аудитын үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах бүртгэл, баримт, бусад мэдээллээр цаг тухайд нь ханган ажиллана гэдэгт итгэж байна. Аудитын үйлчилгээнд хамрагдах санхүүгийн болон холбогдох бусад бүх мэдээллийн үнэн, зөвийн баталгааг бичгээр гаргаж өгөхийг хүсэх болно. Бидний ажлын хөлс нь гэрээнд гарын үсэг зурагдсанаар урьдчилгаа төлбөрийг нэхэмжлэх бөгөөд гэрээт ажлыг дуусгавар болгосноор үлдэгдэл төлбөрийг нэхэмжлэх болно.

Энэхүү захидалд нэмэлт өөрчлөлт оруулах, эсвэл өөр захидлаар орлуулах, хүчингүйд тооцох шийдвэр гараагүй тохиолдолд гэрээний хугацаа үргэлжлэх дараагийн жилүүдэд хүчин төгөлдөрт тооцно.

Санхүүгийн тайланд хийх аудитын үйлчилгээг танай байгууллага хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлэн гарын үсгээ зурж, баталгаажуулан манай талд ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн:

“Шинэ их тэрбум аудит” ХХК-ийн

Гүйцэтгэх захирал:

/Д.Дашдулам/

Ахлах аудитор:

/Б.Олжаргал/



Хүлээн зөвшөөрсөн:

“Тандэм инвэст ББСБ” ХК-ийн

Захирал:

/Ж.Ганхуудог/

Ерөнхий нягтлан бодогч:

/Б.Болормаа/

